



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Мандал Энерго" ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2026/029/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум 2026 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: "Пийк ОМ Аудит" ХХК Утас: 99862066 Цахим хаяг: peakomauditllc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах зөвлөл

Агуулга

Хоёр.Аудит хийсэн санхүүгийн тайлан	6
Гурав. Аудитын илрүүлэлт.....	11
2. Тайлант оны эцэст харилцагч байгууллагуудтай 32,768.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	12
Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “ <i>Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно</i> ”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “ <i>Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ</i> ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.	12
Шийдвэрлэсэн нь: Жилийн эцэст харилцагчтай тооцоо нийлж, авлага, өр төлбөрийн үлдэгдлийг баталгаажуулж албан шаардлага хүргүүлэв.....	12
Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	13



“МАНДАЛ ЭНЕРГО” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Г.ДАШДАВАА ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № САА-2026/029/НА-СТА-ӨНӨЧГ

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол “Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.6, заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Сумын ИТХ-аар батлагдсан төсвийн нүүрсний зардлыг 13,111.7 мянган төгрөгөөр, тээврийн зардлыг 17,259.2 мянган төгрөгөөр нийт 30,370.9 мянган төгрөгөөр хэтрүүлсэн,
- Тайлант оны эцэст харилцагч байгууллагуудтай 32,768.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,

4326050336

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд “Мандал Энерго” ОНӨААТҮГ нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар 92,295.0 мянган төгрөгийн 2 мвт халаалтын зуух, “Яруу цамхаг” ХХК-иас хандивын хөрөнгөөр 250,000.0 төгрөгийн халаалтын зуух, 2015 оноос хойш тус байгууллагад ашиглагдаж байгаа боловч бүртгэлгүй байсан 19,000.0 төгрөгийн тээврийн хэрэгслийг үнэлгээний байгууллагаар үнэлүүлж, үнэ төлбөргүй орлогоор нөхөн бүртгэсэн, сумын ИТХ-ын шийдвэрээр 35,563.0 мянган төгрөгийн газар зэрэг хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд орлогыг 1,785,032.8 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,765,797.4 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,915.851.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,901,014.9 мянган төгрөгийн зардал гарган, 14,836.9 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын 2025 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

Хоёр.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	358,617.68	379,955.71
1.1.02	Дансны авлага	30,773,173.66	45,805,566.67
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	28,487,555.12	
1.1.04	Бусад авлага	5,949,024.43	13,601,544.36
1.1.06	Бараа материал	244,032,910.41	205,587,650.72
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,174,199.36	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	317,775,480.66	265,374,717.46
1.2.01	Үндсэн хөрөнгө	890,906,855.89	1,254,023,308.18
1.2.02	Биет бус хөрөнгө	2,772,000.00	1,584,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	893,678,855.89	1,255,607,308.18
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,211,454,336.55	1,520,982,025.64
2.1.1.01	Дансны өглөг	84,597,822.42	42,486,054.80
2.1.1.02	Цалингийн өглөг	504,108.12	0.00
2.1.1.03	Татварын өр	24,594,536.81	20,327,368.88
2.1.1.04	НДШ - ийн өглөг	50,430,150.04	0.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	6,481,274.80	1,627,176.30
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	166,607,892.19	64,440,599.98
2.2	Өр төлбөрийн нийт дүн	166,607,892.19	64,440,599.98
2.3.02	- хувийн	250,535,268.80	250,535,268.80
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,632,360.38	2,632,360.38
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	984,726,934.74	1,381,584,934.74
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-193,048,119.56	-178,211,138.26
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	14,836,981.30
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-193,048,119.56	-193,048,119.56
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,044,846,444.36	1,456,541,425.66
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,211,454,336.55	1,520,982,025.64

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,696,724,890.18	1,855,787,385.59
02	Борлуулалтын өртөг	1,567,356,332.70	1,704,944,230.49
03	Нийт ашиг(алдагдал)	129,368,557.48	150,843,155.10
04	Түрээсийн орлого	-	1,650,000.00
05	Хүүний орлого	-	-
06	Ногдол ашгийн орлого	-	-
07	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
08	Бусад орлого	8,903.58	58,414,501.89
08.1	Орлогын дүн	8,903.58	60,064,501.89
09	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	155,616,612.59	193,034,631.40
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-

12.1	Зардлын дүн	155,616,612.59	193,034,631.40
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-4,325,624.00	-1,387,490.89
17.1	Олз, гарзын дүн	-4,325,624.00	-1,387,490.89
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-30,564,775.53	16,485,534.70
19	Орлогын татварын зардал	336,392.49	1,648,553.40
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-30,901,168.02	14,836,981.30
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-30,901,168.02	14,836,981.30
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	250,535,268.80	903,851,934.74	-157,330,313.54	997,056,890.00
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-4,816,638.00	-4,816,638.00
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-30,901,168.02	-30,901,168.02
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	80,875,000.00	-	80,875,000.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	250,535,268.80	984,726,934.74	-193,048,119.56	1,042,214,083.98
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	14,836,981.30	14,836,981.30
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	396,858,000.00	-	396,858,000.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	-

Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	2,632,360.38
2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	250,535,268.80	1,381,584,934.74	-178,211,138.26	1,456,541,425.66

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,937,753,223.33	2,016,295,593.19
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,852,398,451.11	2,005,572,273.11
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	30,301.70	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	5,000,004.00	90,270.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	80,324,466.52	10,633,050.08
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,954,850,969.40	2,010,541,382.66
1.2.1	Ажиллагчдад төлсөн	478,249,226.40	449,101,839.06
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	96,851,250.28	190,419,780.02
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	667,049,463.90	880,786,407.53
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	208,647,194.89	158,282,434.14
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	185,241,039.84	125,986,726.88
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	1,261,887.23
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	192,829,269.41	110,510,856.90
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	182,925.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	125,983,524.68	94,008,525.90
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-17,097,746.07	5,754,210.53
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-81,500.00	0.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8	Бусад	-81,500.00	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	891,000.00	8,789,500.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	8,789,500.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	891,000.00	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6	Бусад	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-972,500.00	-8,789,500.00

3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Бусад	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-18,070,246.07	-3,035,289.47
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,428,863.75	358,617.68
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	358,617.68	379,955.71

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2025 он			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:					-	
1	Боловсруулсан ЦЭХ	сая.квтц	-	-	-	
	Боловсруулсан ДЭХ	мян.Гкал	31.1	31.1	0.03	100.1
	ДХЦЭХ	сая.квтц	-		-	
	ЦЭХ-ийн түгээлт	сая.квтц	-		-	
	ДЭХ-ийн түгээлт	мян.Гкал	26.7	26.7	(0.02)	99.9
2	Нийт орлого	м.төг	1,785,032.7	1,915,851.8	130,819.08	107.3
3	Нийт зардал	м.төг	1,765,797.3	1,899,366.3	133,569.00	107.6
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	133,035.8	193,034.6	59,998.79	145.1
4	Татварын өмнөх ашиг	м.төг	19,235.4	16,485.5	(2,749.92)	85.7
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	19,235.4	14,837.0	(4,398.44)	77.1
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	294,668.2	299,878.4	5,210.14	101.8
	а/ Орлогын татварт	м.төг	-	-	-	
	б/ НӨТ	м.төг	160,885.5	73,504.9	(87,380.59)	45.7
	в/ НДШ	м.төг	74,185.8	190,419.8	116,233.98	256.7
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	59,348.7	35,573.6	(23,775.05)	59.9
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	-	-	-	
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	248.3	213.0	(35.30)	85.8

	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	-	167.1	167.10	
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг			-	
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	32.0	32.0	-	100.0
9	Нийт цалингийн сан	м.төг	593,486.5	572,768.7	(20,717.80)	96.5
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	1,545.5	1,491.6	(53.95)	96.5
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	1.0	1.0	0.00	100.2
12	Хөрөнгө оруулалт	м.төг		461,887.5	461,887.50	
13	Нийт авлага	м.төг	65,209.80	61,055.7	(4,154.10)	
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	
14	Нийт өглөг	м.төг	166,607.80	64,440.6	(102,167.20)	
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	166,607.80	64,440.6	(102,167.21)	
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	-	-	-	

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 13,230.4 мянган төгрөгийн дараах алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагааны орлогыг 11,581.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тайлагнасан;
- Орлогын дэлгэрэнгүй тайланд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын зардал 1,648.6 мянган төгрөгийг тусгаагүй;

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд СТОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” стандарт болон “*Үнэлгээ ба хуваарилалт*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 123,374.8 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөрчил арилгуулах 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **63,139.6** мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 45,909.9 мянган төгрөгөөр их тул “**Хязгаарлалттай**” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

1.Тус ОНӨААТҮГ нь сумын ИТХ- аар батлуулсан нүүрсний зардлыг 13,111.7 мянган төгрөгөөр, тээврийн зардлыг 17,259.2 мянган төгрөгөөр нийт 30,370.9 мянган төгрөгөөр зардлыг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл. “Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг” 20.1.2 дэх “*үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах;*”, 20.1.3-дахь “*Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан, биелэлтийг хангах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлыг үндэслэлтэй төлөвлөх, шаардлагатай тохиолдолд сумын ИТХ-д өргөн мэдүүлж, батлагдсан төсөвт өөрчлөлт оруулах албан шаардлага хүргүүлэв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Тайлант оны эцэст харилцагч байгууллагуудтай 32,768.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “*Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцэст харилцагчтай тооцоо нийлж, авлага, өр төлбөрийн үлдэгдлийг баталгаажуулж албан шаардлага хүргүүлэв.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн бүртгэлд 60,235.2 мянган төгрөгийн өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй, 95 ширхэг үндсэн хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх саналыг хүргүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 дахь “ *... элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*”, НББОУС-16 “Үндсэн хөрөнгө” гэсэн заалтууд болон “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох, актлах саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Орлогыг илүү тайлагнасан.	1	11,581.8			1	11,581.8	1	11,581.8				
Орлогын дэлгэрэнгүй тайланд албан татварын зардлыг тусгаагүй.	1	1,648.6	1	1,648.6			1	1,648.6				
Дүн	2	13,230.4	1	1,648.6	1	11,581.8	2	13,230.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сумын ИТХ-аар зардлаа нэмж батлуулаагүй.	1	30,370.9			1	30,370.9						
Дулааны авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	32,768.7			1	32,768.7						
Өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлж шийдвэрлээгүй	1						1					
Дүн	3	63,139.6			2	63,139.6	1	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хугацаа хоцроож, мэдээллийг огт мэдээлээгүй.	4	1					1			
Нийт дүн	1						1			